



“ЖУУЛЧИН ГОВЬ” ХУВЬЦААТ КОМПАНИИ

2025 оны 03 сарын 17 өдөр

№ 02

Улаанбаатар хот

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит
хурлыг зарлан хуралдуулах тухай

Компанийн 2025 оны 03 дугаар сарын 17- ны өдрийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хурлын шийдвэрийг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. “Жуулчин говь” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2025 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн 13:00 цагт “Монгол савхи” ХК-ийн хурлын танхимд хуралдуулсугай.
2. Хувьцаа эзэмшигчдын ээлжит хурлаар доор дурьдсан асуудлыг хэлэлцэхээр тогтоосугай.
 - Компанийн 2024 оны үйл ажиллагааны тайлан
 - Компанийн ТУЗ-ийн тайлан
 - Аудитын хорооны тайлан
 - ТУЗ-ийн гишүүдийг сонгох
3. Хурал зохион байгуулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилон ажиллуулсугай.
 - Комиссын дарга: Д.Сүрэнхорол
 - Комиссын гишүүд: Г.Хүрэлбаатар, Ц.Мөнхнасан
4. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын даргаар Г.Мөнхбилэгийг томилсугай.
5. Хурлын тооллогын комиссыг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.
 - Комиссын дарга: Д.Сүрэнхорол
 - Комиссын гишүүд: Г.Хүрэлбаатар, Ц.Мөнхнасан
6. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын зар мэдээг хүргэх, хуралтай холбогдох асуудлыг зохих хууль, журмын дагуу эрхлэн явуулахыг хурал зохион байгуулах комисст даалгасугай.
7. Ээлжит хурлын зарыг олон нийтэд хүргэх өдрийг 2025 оны 03 дугаар сарын 21 ны өдрөөр, бүртгэлийн өдрийг 2025 оны 04 дүгээр сарын 07-ны өдрөөр тус тус тогтоосугай.
8. Хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчид нь хавсралт 1-д заасан бичиг баримттай танилцах бүрэн эрхтэй болохыг дурьдсугай.
9. Хувьцаа эзэмшигчдын ээлжит хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдээс Энэхүү хурлаар хэлэлцэх асуудлаар санал авах саналын хуудасны агуулгыг хавсралт 2-т зааснаар баталсугай.
10. Саналын хуудсыг хүлээн авах сүүлчийн өдрийг 2025 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн 13:00 цагаар тасалбар болгосугай.

ТУЗ-ийн ДАРГА



Г.МӨНХБИЛЭГ